



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/332

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гүрж улсын нийслэл Тбилис хотод зохион байгуулагдах Самбо бөхийн өсвөр үеийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох Хэрлэн 1 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Бямбадорж овогтой Жигжиддоржид онгоцны тийз, байр хоолны зардалд 500.000 /таван зуун мянган төгрөг/-ийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн өсвөрийн шигшээ багийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА